

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Оогоо	Дугаар	L147
Оршин суугаа аймаг	Баянхонгор	Оршин суугаа сум	Бууцагаан
Төрсөн газар		Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Дарь эхийн жас	Сүм хийдийн дугаар	БХБН 077
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 10	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан



Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Дарь эхийн жас

Асуулт:-Энэ сумын нутагт байсан Дарь эхийн жасын талаар ярьж өгнө үү.

Хариулт:-Манай Баянхонгор аймгийн Бууцагаан сумын нутагт дээр үеийн нэлээн олон хийдүүд олонтой байсан юм. Энэ дотроос хамгийн олон лам нар сууж байсан, хамгийн нэр хүндтэй, хамгийн томоохон нь Дарь эхийн жас гэж байсан, Дарь эхийн хурал гэж хуралддаг байсан байна. Энэ нь одоогийн Бууцагаан сумын **төвийн доохно** туурь нь тэнд байдаг. Тэр үеийн хөгшчүүлийн ярьж, бидний зарим зүйлийн мэдэж байгаагаар үзэх юм бол энэ их олон сайхан дугантай байсан юм гэнэ лээ. Яг тооны хувьд авч үзэх юм бол олон баганатай, улаан дуган гэж том дугантай, 6 жижгэвтэр дуган байсан, энд дандаа голдуу хурал номын ажлуудыг хийдэг байсан. Энэ голдуу чулуугаар барьсан байсан, зарим нь ч мөн тоосго байсан. Гэхдээ гол нь баганын модыг бүр хангайгаас дамнуулж, цуварсан үхэр тэргээр авчирч энд дуган босгож байсан түүх намтар, өвгөчүүл ярьдаг юм билээ.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Олон сайхан баганатай, багана болгон дээр нь хүчтэнийг уран биеэр оруулсан, их гайхамшигтай сайхан дугануудтай, хожим эд нарыг хоршооны ноос авдаг газар болгож, агуулах байлгаж байгаад сүүлд нь буулгаад тал тийш нь байшин барилга, малын хашаа саравчинд хэрэглээд ингээд дуусгасан ийм байсан юм гэнэ лээ.

Асуулт:-Гол шүтээн нь ямар бурхан байсан юм бэ?

Хариулт:-Дарь эхийн жасын хамгийн гол шүтдэг бурхан нь бол Ногоон дарь **эх бурханыг** шүтдэг байсан юм. Одоо сумын төв дээр байж байгаа жижиг дарь эхийн сүм ч гэсэн Ногоон дарь **эх бурханаа** шүтдэг, тахидаг ийм учиртай юм. Ногоон дарь эхийн шүтлэгтэй байсан.

Асуулт:-Энэ хийдийн гол том лам нараас нэрийг нь мэдэж байна уу?

Хариулт:-Том лам нар нь дээр үеийн түрүү үеийн улсуудын ярьж байгаагаар бол Цэгмид ловон гэж байсан байна. Лувсандамба унзад гэж байсан байна. Авид цорж гэж байсан, Дарин цорж гэж байсан, Нанзад гэлэн, Сандаг **омбо**, гавж Цагаан, Цагаан Даш, Чимид ловуу, Лхүмбэ гээд сүүлийн үед нэлээн байсан улсууд бол лам Баатар гуай байгаа, **Нагий** гуай, Лхамсүрэн гуай, Шоод гуай, Адъяа гуай гээд ийм ахмад **хүмүүсүүдийг** бас нэрлэж болохоор ийм байсан юм. Эд голдуу хурал номынхоо хурлыг энэ дугандаа хуралдуулдаг байсан юм. Саяхан энэ сүмийг сэргээж өгсөн, энэ байшин барилгыг барьж би тэнд байж Засаг дарга хийж, хөрөнгө хүч гаргаж бид энэ Дарь эхийнхээ жасыг сэргээж байгуулж байсан ийм учиртай. Одоо бол Тогоогийн Төгс гэдэг лам бас энийг удирдаж байсан. Баттогтох гэдэг банди шашны сүргүүл **төгсч** ирээд бас энэ сүмдээ ажиллаж байгаа. Ийм улсууд сүсэгтэн олны санаачилгаар энэ Дарь эхийнхээ жасыг сэргээх, сайжруулах гэсэн ийм бодлого явуулж байна.

Асуулт:-Дарь эхийн жасаа дээр үед ямархуу уул овоо тахидаг байсан юм бол?

Хариулт:-Манай энд чинь олон жижиг хурлын газрууд олонтой, 10 шахам хурлын газар байсан. Хурлууд болгон бас өөрийн дэг жаягтай, өөр өөрийн хурал номтой, чиглэл чиглэлтэй ийм байсан юм байна лээ. Хамгийн гол нь одоогийн бид нар авч үзэхэд жас газар болгон өөрийн тахилгын газартай байсан байна. Хажуудаа дандаа л зууны тэргүүн сард л тэр уул овоогоо тахидаг, бороо хур их ордог, тэр чинээгээрээ хур сайхан буудаг, зун сайхан болдог, мал сүрэг таргалдаг, хүмүүсийн сэтгэлд баяр болдог ийм байсан байна. Жишээ нь, 1-р багийн нутагт байж байгаа тэмээтийн худгийн дэргэд Маналын жас гэж байсан байна. Энэ нэг хүн анх Жанцан гэдэг хүн өөрөө байгуулж, өөрийнхөө хөрөнгөөр байгуулж байсан ийм учиртай. Энэний тахидаг газар нь тэнд Тэмээтийн худаг гэж байгаа. Тэр худгаа тахидаг байсан юм, онцлогтой. Худагтаа цагаан идээ хийдэг, худгаа тойрч тахидаг ийм содон сонин ийм газар байдаг юм.

Данжиг жас байж байгаад **Данжигийн** хурал бол Зүлэгт хэмээх газарт байж байсан. Энэ бол **Зүлэгтийнхээ** урд талын овоотой дэнж толгой байгаа, тэнд гарч тахидаг байсан. Энэ дандаа зуны эхэн саруудын зуны хур бороо эхлэх үед л, лусын буулттай өдрүүдээр голдуу тахидаг байсан юм гэнэ лээ. Цагаан идээгээр тахидаг байсан юм гэнэ лээ.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Зүүн жас гэж байсан. Энэ тэр **Зүлэгтийн ширгэний** цаад талд орж ирсэн хоолойд дүүрэн байшин барилга байсан. Сүүлд Эвлэлийн залуучуудын хүчээр хороо хашаа бариад өнгөрсөн. Эднийх Махгал бурхан тахидаг байсан юм гэнэ лээ. Жанчив дайчин гэдэг хүн байгуулж байсан. Сүүлд Өөлдийн дайнд яваад эргэж ирэхдээ **алтан Ганжуур, Жадамба** судар олж авчирсан ийм домог энд бас байдаг юм. Энэ зүүн жасын лам нар мөн л дэргэдээ бас тахидаг газартай, урд талынхаа овоон дээр очоод энэ хурлынхаа юуг хийдэг ийм байсан байна.

Мөн Тариан жас гэж байсан, Юмын жас гэж байсан. Юмын жасын урд Нарангийн төвийн хажууханд байгаа жижиг бондгор ягаан толгой байгаа. **Тэрэн** дээр дандаа тахидаг, саяхан болтол Лхамсүрэн гуай тахиж байсан. Энэ жил хүртэл аймгаас лам нар авчраад тэр хавийн улсууд тэр толгойг тахиж бороо хур оруулах гэж оролдож байдаг ийм учиртай юм даа. Ийм ийм тахилгын уулуудтай. Энэ аль ч жас өөр өөрийн тахидаг уулуудтай байсан. Энэ бол бас л их хэрэгтэй байсан юм шиг байна лээ шүү, энийг цаашдаа.

Гэхдээ яг цагаан тахилгатай юу, хар тахилгатай юу, ямар тахилгатай байсан юм бэ? гэдгийг одоохондоо яг тийм ном судар алга байна. Хуучин байсан улсууд, өвгөчүүлийн яриа, улбаагаар хөөхөд цагаан тахилгатай, голдуу ингэж тахидаг байсан гэж ингэж ярьдаг юм байна.

Асуулт:-Энэ **жасд** Энэтхэг, Төвдөөс лам нар ирж ном зааж байсан уу?

Хариулт:-Яг тодорхой Төвдөөс тийм хүн ирж байсан гэдэг нь одоохондоо мэдээ байхгүй юм байна лээ.

Асуулт:-Цам, **Майдар** байсан уу?

Хариулт:-Цам, **Майдар** хамгийн их том жас байгаа шүү дээ, Дарь эхийн жас. Дарь эхийн жас дээр цам, **Майдар гардаг**, хурал номоо хурдаг, тэр чинь хамгийн том нь байсан юм байна лээ. Тэрэндээ **том Майдартай** байсан.

Асуулт:-Хэдэн сард гардаг байсан юм?

Хариулт:-Яг тэдэн сар гэж өдөр сар нь бичигдсэн юм байхгүй. Дээр үед энд сууж байсан Баатар гуайн ярьж байснаар бол зуны эхэн сарын шинийн 3, шинийн 8, 15-даар цам, **Майдар** гаргадаг, манай энэ Дарь эхийн жас Ногоон дарь **эх бурханыг** тахидаг байсан гэж ярьдаг байсан. Тэрнийг л бичиж авч цуглуулж энэ ном, соёл, сумын түүхэн **танилцуулганд** оруулж байгаа юм л даа.

Асуулт:-Энэ хийдэд олонд алдартай том лам нар байсан уу?

Хариулт:-Тийм юм байхгүй. Бидний үед жаахан дамжиж ирсэн нь **Магий** гуай гэж хүн байгаа даа, тэр хүн зурхайч байсан юм гэнэ лээ. **Магий** гуайн аав нь удам судар хөөвөл Дарьзав зурхайч гэж мундаг сайн хүн байсан юм гэнэ лээ. Дараа нь **Магий** гуай зурхай зурж байсан. Манай Бууцагааны түрүүн үед байсан, номоороо алдаршиж байсан улсууд нь **Магий** гуай л юм даа, **Магий** гуай зурхайн **номондоо** их сайн байсан хүн юм гэсэн.

Асуулт:-Урсгалын хувьд аль урсгал?

Хариулт:-Дандаа л шарын шашны л урсгал даа. Бурханыхаа номыг л гол нь барьж, шүтэж биширч байсан. Харин сүүлд улааны шашин гээд зарим нь бас нэг жаахан гарч ирж байгаа хүүхдүүд хоорондоо бас нэг эрдэм номын төрлөөр юмуу даа маргалдах төрөл бас харагдаж л байдаг юм. Гэхдээ чиглэл чиглэлээ барьдаг юм байна л даа, тэд нар чинь.

Асуулт:-Энэ хийд хэд орчим оны үед байхгүй болов?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Гол нь 30 хэдэн оноос хойш л тэр хэлмэгдүүлэлтээс хойшхи үед л сүм дуганууд байхгүй болсон доо. Томоохон лам нарыг их барьсан шүү дээ. Сандаг гуай гээд л. Чимид ловон гэдэг хүн баригдаад явж байсан. Голдуу Юмын жасын хавьд суудаг байсан юм биш үү. Хожим цагаатгагдаж барьж юм нь гарч ирж байсан. Цагаатгалын номон дээр бас гарсан байна лээ дээ, Чимид ловон гуай эд нар гарч ирсэн. Яг энэ үеэр л лам нарыг нь бариад л, хүрээ хийдийг устгасан юм билээ.

Асуулт:-Бурхан шүтээн нь

Хариулт:-Улсууд янз болгоноор ярих юм даа, зарим нь тэмээ **маланд** ачиж аваачаад хад руу, ус руу хаясан гэдэг юм, зарим нь уул хаданд хийсэн гэдэг юм. Яг нотлох тодорхой баримтаар тэнд аваачиж тэгсэн гэх юм байхгүй юм байна. Байшин барилгыг нь нураагаад, нурууны модыг нь энд тэндхийн малын хашаа саравчинд хэрэглээд, хоршооны байшин барихад бариулаад ингээд дуусгасан юм байна лээ.

Асуулт:-Тухайн үед эхлээд барьж байхад нь ямар мужаанууд барьж байсан юм бол, монголчууд өөрсдөө барьж байсан уу?

Хариулт:-Голдуу манай өөрийн нутгийн мужаан нар л цуглаж барьж байсан юм биш үү, гол нь энэ их холоос тийм мужаан барьж байсан юм билээ гэж яригддаггүй юм. Голдуу л нутгийн монгол, өөрийн мужаан нараар л бариулж байсан ийм л сайхан дуганууд байсан гэж ярьдаг юм. Архангайн бүр араас явж том том мод, хурлынхаа байшингуудын модыг, дугануудынхаа багануудыг ачиж ирж байсан ийм л юм гэсэн шүү.

Асуулт:-Энэ жас хэд орчим малтай, мал хуйгаа яаж хариулж малладаг байсан юм бол?

Хариулт:-Энэ жас болгон өөрийн хэд хэдэн малтай, хамгийн их баян малтай нь Дарь эхийн жас байсан. Манал жас адуутай байсан. Манал жас бол хамгийн олон адуутай, Дарь эхийн жасын адуу гэж их хурдан адуутай, **Шинтүүн** хүрэн гэж хурдан хүрэн морины домог хүртэл байсан. Энэ жасын юм гэнэ лээ. Дарь эхийн жас гэдэг бол өөрөө их баян жас, хүрэл тулгатай, 10 мянга гаруй малтай байсан юм гэдэг шүү. Их л олон малтай. Улсууд голдуу гэрээгээр малыг нь малладаг, өсгөж өгдөг, Дарь эхийн мал малладаг, жасын мал малладаг ийм л байсан юм гэсэн.

Асуулт:-Татвар төлдөг байсан уу?

Хариулт:-Манай Дарь эхийн жасын бас нэг сонин юм нь их том хүрэл тулгатай байсан юм гэнэ лээ. Тэгээд тэр том хүрэл тулга нь сүүлд хожим улсын Төв музейд хүлээлгэж өгсөн гэж манай нутгийн өвгөчүүл ярьдаг. Төв музейд байгаа том хүрэл тулга бол энэ Баянхонгорын Бууцагаан сумын Дарь эхийн жасын тулга тэнд очсон ийм түүх намтар бидэнд бас байдаг юм.

Татварыг би тодорхой мэдэхгүй юм. Яг тийм татвар төлж байсан гэсэн тийм юм тодорхой түүхэнд үлдсэн бичиг баримт байхгүй юм билээ. Татвар төлж байсан юмүү, үгүй юу би тэрнийг сайн мэдэхгүй юм байна даа.

Асуулт:-Энэтхэг, Төвдийн хийдүүдтэй холбоотой байсан юм болов уу?

Хариулт:-Тэрнийг миний түрүүний ярьсан зурхайч, **Магий** гуай төвдөд очиж ном үзнэ гээд хавчиг үүрэг, хоёр таягаа бэлдчихээд ингээд урьдчилан бэлтгэлээ **хийчихээд** яг явах гэж байсан энэ үед нь 32 оны хувьсгалын **эсэргүү** гэж ярьдаг байсан даа, тийм юм гараад тэгээд **Магий** гуай явж чадахгүй болоод тэр дороо явах гэж

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

байснаа **больчихоод** замаасаа гараад тариа ногоо тариалаад Өлзийтийн голд тариа ногоо тариад ингээд лам биш байсан гээд ингээд үлдчихсэн ийм учиртай юм билээ. Тийм учраас **тийшээ** явж байх, мэдэж байх, тийшээ даялж очиж ном үзэх гэсэн ийм хандлага манай эндхийн лам нар дотор байсан гэж би бас боддог юм.

Асуулт:-Дарь эхийн жас өөрөө ном барладаг, модон бар байсан уу?

Хариулт:-Модон барын юм тэнд байхгүй. Манай энд байсан юм. Төвд ном нэлээн үзэж байсан **Жогдын** Цэдэв гэж. Тэрэнд хэдэн модон бар байсан юм. Тэгээд манай энэ жасын модны бар уу гэж Цэдэвээс лавлаж байсан юм. Манайх бишээ, энэ өөр газраас цуглуулж ирсэн юм байгаа юм гэж. Тэр Цэдэв бас лам хүн л даа, багш хүн байсан. Гэхдээ тэр ном соёлын зүйл цуглуулдаг ийм хүн байсан. Тэгээд тэр зайлуул хот руу шилжээд явчихсан, модон баруудаа яасан юм мэдэхгүй. Гэхдээ манай энд барлаж байсан тийм түүх байхгүй юм шиг байна.

Асуулт:-Хэлмэгдүүлэлтийн үед баригдсан лам нар бүгд байхгүй болж байсан уу? эргэж ирсэн хүн байгаа юу?

Хариулт:-Эргэж ирсэн хэлмэгдүүлэлтээс баригдаад явсан лам нараас яг тэр гуай эргэж ирсэн гэсэн юм байхгүй юм билээ. Голдуу эргэж ирээгүй юм биш үү. Буян-Өлзий гуай явсан гэсэн тэр эргэж ирээгүй гэсэн, Сандаг гуай эргэж ирээгүй, тэгээд ер нь байхгүй дээ.

Асуулт:-Буян-Өлзий гуай аль жасад хурж байсан юм бол?

Хариулт:-Буян-Өлзий гуай Юмын жасын хавьд байсан юмуу, манай яг л 5-р багийн хүн шүү, уг нь.

Асуулт:-Тэр хийдэд ямар албан тушаалтай байсан юм бол?

Хариулт:-Яг хийдэд сууж байгаагүй, хааяа нэг хурал номонд очдог, гэхдээ голдуу хөдөө хэдэн малтай, тэгээд лам хүн гээд тэгээд тэр орон нутаг дотроо том лам гээд ингээд нэрд гарчихсан. Тэрүүгээр нь чи том лам хүн гээд барьж аваад явсан ийм л учиртай юм байна даа. Тэр үед чинь бас зарим нь нутгийн ардууд бие биенийгээ муулаад, бараг лам биш байгаа юмыг чинь өс хонзонгоор тэр лам тэнд ингэж байсан, энэ том толгой лам гэж аваачиж хөөж бариулаад хачин юм их болж байсан юм байна л даа. Одоо хойно очоод судалж үзэж байхад. Яг дандаа хурал номын газрууд, жас **жаваар** байсан лам нар баригдсан биш, зарим нь хөдөө байсан лам нь лам байсан. Гэхдээ тийм улсуудыг бас улсын хатгалгаар баригдаад **явчихаж** байсан тийм юм бас байдаг юм байна лээ.

Асуулт:-Баригдаагүй хүмүүс нь тэгээд ногоо тариад, мал маллаад?

Хариулт:-Манай **Магий** гуай, Баатар гуай эд нар шалавхан лам биш болоод тэгээд хоршоо, **артель** гэж тэр үед байсан. **Артель** байгуулаад тэнд чинь ажил хийгээд мужаан хийгээд, зарим нь ногоо тариад, зарим нь нэгдлийн мал маллаад ингээд гарч байсан л даа. Тэгэхээр нөгөөдөх чинь би лам бишээ, **яхав** дээ ганц нэг тарни мэддэг байсан биз, тэгээд би голдуу нэгдэлд ажиллаж байна, нийгэмд хүчээ үнэлж байна, би ямар ч лам биш гэхээр тэр хүнийг барих юм гарч байгаагүй байсан байна. Тэгээд ажлаа хийгээд явж байдаг, ингээд үлдэж байсан юм.

Асуулт:-Жас тус бүрийн лам тоо?

Хариулт:-Мэдэхгүй.

Асуулт:-Бууцагаан сумын төв дээр шинээр байгуулагдсан хийдийн тухай ярьж өгөхгүй юу? хэдэн онд ямар нэртэй хүмүүс анх санаачилж байгуулав.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Бууцагаан сумын төв дээр 1994 онд Бууцагаан сум байгуулагдсаны 70 жилийн ой болсон байхгүй юу. Энэ 70 жилийн ойд бид нар бас тодорхой бүтээлч юм хийх ийм санаачилга гаргаж юм цуглуулж, тодорхой бүтээлч ажлуудыг хийж байсан. Энэ үед л дахиж Дарь эхийнхээ жасыг сэргээе гэдэг ийм үүсгэл санаачилга гарч, энэ гол нь Баатар гуай, Лхамсүрэн гуай, **Магий гуай**, тэр үед байсан Адъяа, Шоод гэсэн ийм лам нар, хуучин ажиллаж байсан лам нар санаачилга гаргаад, тэрнийг нь төрийн захиргааны байгууллагууд нэлээн дэмжээд тодорхой хэмжээний хөрөнгө хүч гаргаад ингээд тэр жилдээ жижиг гэр хэлбэртэй дуган хэлбэртэй байшин бариад. Тэгээд тэндээ хуучин байсан лам нар өөрсдөө суугаад, өөрсдөө Ногоон дарь эхийнхээ **бурханыг** томоор бүтээлгээд, өөрсдөө судраа олж ирж тавиад тахил номоо худалдаж аваад ингээд энэ хурал номынхоо газрыг эхэлж байгуулж ингэсэн хэрэг л дээ. Тэрнээс хойш **яахав** тасралтгүй ажиллаад ингээд явж байгаа юм байхгүй юу. Цаашдаа хүүхдүүд шашны их сургуулиар явж хүүхдүүд бэлтгээд ингээд одоо бол хэд хэдэн хүүхэдтэй, хааяа тодорхой **өдрүүдээр** хурал номоо хурдаг ингээд нэг ийм газартай ийм байдаг юм байна. Тогтмол цагийн өдөр болгоны хурал гэж юм байхгүй. Цөөхөн ламтай. Шинийн 3, шинийн 8 , шинийн 15, 29-нд л хурал номоо хураад л, улсуудын хүсэлт санал гаргавал **яахав** тэр тодорхой хэмжээний хүмүүст хэрэгцээтэй номыг нь уншиж өгөөд ингээд байдаг ийм л журамтай. Одоо бол Баттогтох лам ажиллаж байгаа тэнд.